

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 08 дугаар сарын 25

Тендер шалгаруулалтын нэр: “Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороо, Сурагчийн 84 дүгээр гудамжны Ахмадын талбайн тохижилтын ажил”

Тендер шалгаруулалтын дугаар: ЧДХААА А17/052

Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороо, Сурагчийн 84 дүгээр гудамжны Ахмадын талбайн тохижилтын ажил”-ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн материалыг цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50.000 /тавин мянга/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны меркантын системийг ашиглан төлнө.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын орлогын дундаж хэмжээ: Сүүлийн 2 жил /2015, 2016/-ийн дундаж нь 70 000 000 /далан сая/ төгрөгөөс багагүй байна.

Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн ажлын туршлагын талаар мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2015, 2016/-ийн аль нэг жилд ядаж нэг удаа 70 000 000 /далан сая/ төгрөгөөс багагүй үнийн дүнтэй гадна тохижилтын ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 30 000 000 /гучин сая/ төгрөгөөс багагүй байна.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2015, 2016/-ийн жилийн эцсийн санхүүгийн тайлан

Шаардлагатай тусгай зөвшөөрөл:

Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог:

2.1.1 Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт

Тендерийн хамт 1 700 000 /нэг сая долоон зуун мянга/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 11 цаг 00 минутаас өмнө цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 11 цаг 30 минутанд нээнэ.

Гадаадын этгээд: Оролцох эрхгүй

Дотоодын давуу эрхийн зөрүү: Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, IV хороо, Ж.Самбуугийн гудамж-16, Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр, Худалдан авах ажиллагааны алба 511 тоот өрөө, Утас : 70110769